

## **ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР ИРҮҮЛСЭН САНАЛЫГ СУДАЛСАН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

### **Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, олон нийтийн хэлэлцүүлгийн талаар**

Монгол Улсын Их Хурлаас Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 онд баталснаас хойш гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, давтамж, хамрах хүрээ өөрчлөгдөж, хуулийг хэрэгжүүлэх явцад зарим зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүссэн.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2025 онд хийсэн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр нэр томьёо, гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал, улсын хяналт, эрсдэлийн үнэлгээ, удирдлага, зохион байгуулалт, оролцогч талуудын эрх, үүрэг, сайн дурын оролцоо, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэсэн.

Үүний дагуу хуулийн төсөлд гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал, улсын хяналт, сургалт, удирдлага, зохион байгуулалт, иргэн, хуулийн этгээд, сайн дурын ажилтны оролцоо, Онцгой байдлын байгууллагын тогтолцоо, алба хаагчийн нийгмийн баталгаа, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилт зэрэг үндсэн зохицуулалтыг боловсронгуй болгохоор тусгасан.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.1-д заасны дагуу хуулийн төсөлд олон нийтийн санал авах нээлттэй хэлэлцүүлгийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2026 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан удирдамжийн дагуу 2026 оны 07 дугаар сарын 01-06-ны өдрүүдэд 21 аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан.

Хэлэлцүүлгийн үр дүнд хуулийн төслийн зохицуулалтыг дэмжих, өөрчлөх, нарийвчлах, шинээр зохицуулалт нэмэх болон хуулийн хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой нийт 107 санал ирснийг нэгтгэн судлав.

### **Хоёр. Олон нийтийн хэлэлцүүлгээр ирүүлсэн саналын ерөнхий агуулга**

Олон нийтийн хэлэлцүүлгээр ирүүлсэн саналуудыг агуулгаар нь судлахад гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт, орон нутгийн удирдлага, хүний нөөц, улсын хяналт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт, сайн дурын оролцоо, дайчилгаа, нөхөн төлбөр, сургалт, алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаа зэрэг асуудал голлон хөндөгдсөн байна. Түүнчлэн зарим асуудлаар хэд хэдэн аймаг, орон нутгаас ижил, ойролцоо агуулгатай санал ирүүлсэн нь хуулийг хэрэгжүүлэх явцад нийтлэг тулгарч буй асуудлыг тодорхойлох ач холбогдолтой байна.

Тухайлбал, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийн талаар Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.2-т заасан хөрөнгийг орон нутгийн төсөвт бүрэн тусгах, зориулалтын дагуу зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх, Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн эх үүсвэр, зарцуулалтыг тодорхой болгох санал ирүүлсэн. Энэ чиглэлээр хуулийн төсөлд аймаг, сум, нийслэл, дүүрэгт Гамшгийн

эрсдэлийг бууруулах сан байгуулах, сангийн эх үүсвэр, хөрөнгийн зарцуулалт, удирдлагатай холбоотой үндсэн зохицуулалтыг тусгасан.

Орон нутгийн удирдлага, хүний нөөцийн талаар сумын түвшинд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тогтмол хариуцан зохион байгуулах ажилтан, алба хаагчтай болох шаардлагатай гэсэн санал хэд хэдэн аймгаас ирсэн. Энэ асуудлыг шийдвэрлэх хүрээнд хуулийн төсөлд Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын Тамгын газарт Онцгой байдлын байгууллагын нэг алба хаагчийг томилон ажиллуулах зохицуулалтыг тусгасан.

Гамшгаас хамгаалах улсын хяналтын талаар улсын байцаагчийн эрх хэмжээ, хяналтын чиглэл, хамрах хүрээг тодорхой болгох санал ирүүлсэн. Хуулийн төсөлд гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах болон аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд улсын байцаагч хяналт тавих эрх зүйн үндсийг тодорхой болгохоор тусгасан.

Гамшгаас хамгаалах төлөвлөлт, эрсдэлийн үнэлгээний талаар аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны онцлог, цар хүрээнд нийцүүлэн төлөвлөгөө боловсруулах шаардлагыг ялгамжтай тогтоох, төлөвлөгөө болон эрсдэлийн үнэлгээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах санал ирүүлсэн. Үүнтэй холбоотойгоор хуулийн төсөлд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах түвшин, шаардлагыг тодорхой болгож, цахимаар үйл ажиллагаа явуулдаг, ажлын байр, объектгүй болон бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг төлөвлөгөө боловсруулах шаардлагаас чөлөөлөх, эрсдэлийн үнэлгээ болон төлөвлөгөөний хэрэгжилтэд улсын хяналт тавих зохицуулалтыг тусгасан.

Сайн дурын оролцоо, дайчилгаатай холбоотойгоор сайн дурын хэсэг, сайн дурын ажилтны сургалт, бэлтгэл, хувцас, багаж хэрэгслийн хангамж, урамшууллыг сайжруулах, гамшгийн үед дайчлагдсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын техник хэрэгсэлтэй холбоотой зардал, нөхөн төлбөрийн асуудлыг тодорхой болгох санал ирсэн. Хуулийн төсөлд сайн дурын хэсэг, сайн дурын ажилтны үйл ажиллагаа, сургалт, бэлтгэл, урамшуулал болон хүч хэрэгсэл дайчлахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгохоор тусгасан.

Үүнээс гадна гамшгаас хамгаалах сургалтын тогтолцоо, гамшгийн даатгал, мэргэжлийн ангийн зохион байгуулалт, Онцгой комиссын үйл ажиллагаа, Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаа болон хуулийн хэрэгжилтийг сайжруулах бусад асуудлаар санал ирүүлсэн байна.

## **Гурав. Саналыг судалсан арга, зарчим**

Олон нийтийн хэлэлцүүлгээр ирүүлсэн 107 саналыг хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл болон дагалдах хуулийн төслүүд, хүчин төгөлдөр хууль тогтоомж, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, төслийн тайлбар, Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн саналтай харьцуулан судлав.

Санал тус бүрийг судлахдаа хуулийн төсөлд туссан эсэх, хүчин төгөлдөр хууль тогтоомжоор зохицуулагдсан эсэх, төслийн үзэл баримтлалд нийцэж байгаа

эсэх, бусад хууль тогтоомжтой зөрчилдөх эсэх, төсөв болон хүний нөөцөд нөлөөлөх эсэх, хэрэгжих боломжтой эсэхийг тус тус харгалзан үзсэн.

Үүний үндсэн дээр саналыг төсөлд тусгасан, хэсэгчлэн тусгасан, өөр зохицуулалтаар шийдвэрлэсэн, хүчин төгөлдөр хууль тогтоомжоор зохицуулсан, эсхүл төсөлд тусгах боломжгүй гэсэн байдлаар ангилан, санал тус бүрийн тайлбар, үндэслэлийг саналын товъёгт тусгав.

### **Дөрөв. Ерөнхий дүгнэлт**

Олон нийтийн хэлэлцүүлгээр ирүүлсэн саналуудыг хуулийн төслийн үзэл баримтлал, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ болон төслийн үндсэн зохицуулалттай харьцуулан үзэхэд хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагын нэлээд хэсэг орон нутгийн практикт бодитоор тулгамдаж байгааг хэлэлцүүлгийн үр дүн давхар нотолж байна.

Ялангуяа гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт, орон нутгийн удирдлага, хүний нөөц, улсын хяналт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт, сайн дурын оролцоо, мэргэжлийн анги, дайчилгаа болон нөхөн төлбөрийн асуудлаар ижил, ойролцоо санал хэд хэдэн аймгаас ирүүлсэн нь эдгээр асуудлыг хуулийн төслийн хүрээнд нэгдсэн байдлаар авч үзэх практик хэрэгцээ байгааг харуулж байна.

Нөгөө талаас олон нийтийн хэлэлцүүлгээр ирсэн санал бүрийг төсөлд механикаар тусгах бус, хуулийн төслийн үзэл баримтлал, бусад хууль тогтоомжтой нийцэх эсэх, төсөв болон хүний нөөцөд үзүүлэх нөлөө, хэрэгжих боломж, зохицуулалтын түвшнийг харгалзан үндэслэлтэйгээр шийдвэрлэх шаардлагатай. Иймд ирүүлсэн 107 саналыг нэг бүрчлэн судалж, төсөлд тусгасан эсэх болон тусгаагүй бол түүний хууль зүйн, бодлогын болон практик үндэслэлийг саналын товъёгийн саналыг судалсан байдал хэсэгт тодорхой тусгав.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ОЛОН  
НИЙТЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁОГ**

2026.08.11

| д/д                                            | Гамшгаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалт | Ирүүлсэн санал                                                                                                                                                                | Саналын тайлбар | Саналыг тусгасан эсэх | Саналыг судалсан байдал                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|------------------------------------------------|--------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|-----------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>1. Архангай (2026.07.07-ны 28/193, ОБГ)</b> |                                                  |                                                                                                                                                                               |                 |                       |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| 1                                              | 12.6<br>Нэмэлт                                   | Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шийдвэрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй. | -               | Тусгах шаардлагагүй.  | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.8-д улсын байцаагч албан шаардлага, дүгнэлт, акт зэрэг хяналт шалгалтын баримт бичиг хэрэглэхээр, 10.9-д улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг, 10.10-д улсын байцаагчийн тодорхой бүрэн эрхийг холбогдох хууль тогтоомжоор тогтоохоор тус тус зохицуулсан байна. Иймд улсын байцаагчийн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хуульд нийтлэг байдлаар давхардуулан зохицуулах шаардлагагүй |
| 2                                              | 12.7<br>Нэмэлт                                   | Дэд бүтцийн барилга байгууламжийг барих ашиглах явц ашиглалтад авах улсын комиссын бүрэлдэхүүнд оролцох, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд санал, дүгнэлт гаргах;            | -               | Тусгах шаардлагагүй.  | Барилгын тухай хуулиар барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажиллагааг тусгайлан зохицуулсан бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга хуульд заасан хүрээнд барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах бүрэн эрхтэй. Мөн эрх бүхий байгууллага ашиглалтад оруулах хүсэлт, холбогдох баримт бичгийг хянаж, ашиглалтад оруулах комисс ажиллуулахаар зохицуулсан байна. Иймд ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах улсын                                       |

|   |                |                                                                                                                                                                                   |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|---|----------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |                |                                                                                                                                                                                   |   |                      | хяналтын байцаагчийг заавал оролцуулахаар Гамшгаас хамгаалах тухай хуульд тусгайлан зохицуулах шаардлагагүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 3 | 12.8<br>Нэмэлт | Иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал эсвэл аюултай нөхцөл байдал үүсэх нь илэрхий тогтоогдсон нөхцөл хяналт шалгалтын удирдамжгүйгээр ажиллах | - | Тусгах шаардлагагүй  | . Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.2-т төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийхээр зохицуулсан. Харин мөн хуулийн 5.3-т хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ноцтой аюул, их хэмжээний хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд хяналт шалгалтын байгууллага, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр удирдамжгүйгээр хяналт шалгалт хийж болохоор тусгайлан зохицуулсан. Түүнчлэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл зэрэг хуульд заасан үндэслэлээр хийх зохицуулалттай. Иймд саналд дурдсан харилцаа Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулагдсан тул Гамшгаас хамгаалах тухай хуульд давхардуулан тусгах шаардлагагүй. |
| 4 | 32.1.15        | Гамшгаас хамгаалах сургалт, дадлага болон гамшиг, аюулт үзэгдэл ослын голомтод үүргээ онц биелүүлсэн алба хаагчдыг шагнаж урамшуулах                                              | - | Тусгах шаардлагагүй. | Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын гамшгаас хамгаалах бүрэн эрхийг хуулийн 32.1-д тусгайлан тогтоосон бөгөөд 32.1.10-т орон нутгийн онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэхээр заасан. Харин гамшгаас хамгаалах сургалт, дадлага болон гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүргээ онц биелүүлсэн Онцгой байдлын                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |

|   |                 |                                                                                                                                                                                                                                                                             |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
|---|-----------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |                 |                                                                                                                                                                                                                                                                             |   |                      | байгууллагын алба хаагчийг шагнаж, урамшуулах асуудал нь Засаг даргын гамшгаас хамгаалах чиг үүрэгт хамаарахгүй тул Засаг даргын бүрэн эрхэд нэмж тусгах шаардлагагүй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
| 5 | 34.13<br>Нэмэлт | Хуулийн этгээд, аж ахуй нэгж байгууллагын удирдлага нь холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан цаг агаарын мэдээг үндэслэж албан ажил, томилолтоор ажиллах, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах талаар заавар, зааварчилгааг өгөх,     | - | Тусгах шаардлагагүй. | Саналд хуулийн этгээдийн удирдлага цаг агаарын мэдээнд үндэслэн албан ажил, томилолтоор ажиллах үед аюулгүй байдлыг хангах талаар заавар, зааварчилгаа өгөх үүргийг шинээр тогтоохоор санал болгосон. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.2-т хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах нийтлэг үүргийг тогтоосон бөгөөд төсөлд 34.2.5-аар гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах болон хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хор уршиг учруулж болзошгүй эрсдэлтэй нөхцөлийг арилгах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр нарийвчлан тусгасан. Иймд албан ажил, томилолт бүрд өгөх заавар, зааварчилгааг хуулиар нэг бүрчлэн зохицуулах бус байгууллагын дотоод зохион байгуулалтаар хэрэгжүүлэх нь зүйтэй |
| 6 | 34.2.5          | Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, холбогдох даатгалд хамрагдах, гамшгийн эрсдэлийг бууруулсан үйл ажиллагааны тайланг харъяа нутаг дэвсгэрийн Онцгой байдлын газар, хэлтэст тогтоосон хугацаанд хүргүүлэх. | - | Хэсэгчлэн тусгасан.  | Саналын гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх агуулгыг хуулийн төслийн 34.2.5-д тусгасан. Тодруулбал, гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн нарийвчилсан үнэлгээ хийлгэх, эрсдэлийг бууруулах болон орчны эрсдэлтэй нөхцөлийг арилгах арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр нарийвчилсан. Харин даатгалд хамрагдах асуудлыг заавал биелүүлэх үүрэг бус хуулийн этгээдийн эрх байхаар төслийн                                                                                                                                                                                                                           |

|   |        |                                                                                                                                                                                                                                     |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
|---|--------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |        |                                                                                                                                                                                                                                     |   |                      | 34.1.5-д “үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн холбогдох даатгалд хамрагдах, даатгалын нөхөн төлбөр авах” гэж тусгасан. Гамшгийн эрсдэлийг бууруулсан үйл ажиллагааны тайланг нутаг дэвсгэрийн Онцгой байдлын газар, хэлтэст тогтмол хүргүүлэх үүргийг бүх хуулийн этгээдэд шинээр ногдуулах шаардлагагүй                                                                                                                                                                                                                                                                                                |
| 7 | 37.2.3 | өдөр тутмын үйл ажиллагаандаа аюулгүй байдлыг хангах, холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан цаг агаарын мэдээ, сэрэмжлүүлгийг үндэслэн зорчих хөдөлгөөнийг баталгаатай зам, даваагаар техникийн бүрэн байдлыг хангаж, үйлдэх, | - | Тусгах шаардлагагүй. | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 37.2.3-т иргэн “өдөр тутмын үйл ажиллагаандаа аюулгүй байдлыг хангах”, 37.2.4-т гамшиг болон аюулаас урьдчилан сэргийлэх арга, техник, багаж хэрэгслийг эзэмшиж, зарлан мэдээлэх дохиогоор ажиллах журмыг дагаж мөрдөх үүрэгтэй байхаар зохицуулсан. Иймд саналын зорилго нь одоо байгаа иргэний аюулгүй байдлаа хангах нийтлэг үүрэгт хамаарч байна. Харин цаг агаарын мэдээ, сэрэмжлүүлгийг үндэслэн “баталгаатай зам, даваагаар”, “техникийн бүрэн байдлыг хангаж” зорчих зэрэг нарийвчилсан шаардлагыг гамшгаас хамгаалах хуульд тусгайлан тогтоох шаардлагагүй. |
| 8 | 49.2   | Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэгүй зорчино.                                                                                           | - | Хэсэгчлэн тусгасан   | Саналын агуулга хуулийн 49.2-т тодорхой хүрээнд туссан. Хуулийн 49.2-т гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч албан үүргээ гүйцэтгэж явахдаа хот, суурингийн дотор нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчихоор зохицуулсан. Хуулийн төсөлд уг зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн хяналтын улсын байцаагч байхаар өөрчлөхөөр тусгасан. Харин уг хөнгөлөлтийг Онцгой байдлын байгууллагын бүх алба хаагчид хамааруулах санал нь одоогийн зохицуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх                                                                   |

|                                                                                                                                                                                                  |                        |                                                                                                                                                                                              |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                                                                                  |                        |                                                                                                                                                                                              |   |                      | бөгөөд нэмэлт төсөв, санхүүжилтийн үр дагавартай тул энэ удаагийн хуулийн төсөлд тусгах шаардлагагүй                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| 9                                                                                                                                                                                                | 49.3                   | Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд тухайн үеийн үндсэн цалинг 10 жилээр тооцож тухайн алба хаагчийн гэр бүлд нэг удаа олгоно. | - | Тусгагдсан.          | Саналын агуулга хүчин төгөлдөр хуулийн 49.3-т тусгагдсан. Тус хэсэгт Онцгой байдлын байгууллагын алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож, гэр бүлд нь нэг удаа олгохоор зохицуулсан. Иймд саналд дурдсан харилцаа одоогийн хуулиар бүрэн зохицуулагдсан тул нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй. |
| <b>2. Баян-Өлгий</b> (2026.07.09 30/182аймаг, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн онцгой байдлын газрын алба хаагчдын саналын хамт) |                        |                                                                                                                                                                                              |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| Саналгүй                                                                                                                                                                                         |                        |                                                                                                                                                                                              |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| <b>3. Баянхонгор</b> (2026.07.06 29/182, ОБГ, Онцгой комисс, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, 20 сумын Засаг дарга, удирдлагын саналын хамт )                             |                        |                                                                                                                                                                                              |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| 10                                                                                                                                                                                               | Хуулийн төслийн 4.1.25 | “нүүлгэн шилжүүлэх” гэж гамшгаас хамгаалах зорилгоор хүн ам мал амьтан эд хөрөнгийг авулгүй орчинд шилжүүлэн байршуулж, орон байраар хангах, арга хэмжээ                                     | - | Тусгагдсан.          | Хуулийн төслийн 4.1.25-д "нүүлгэн шилжүүлэх" ойлголтыг гамшгаас хамгаалах зорилгоор хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг аюулгүй бүсэд шилжүүлэн байршуулж, шаардлагатай тохиолдолд түр байр, орон байраар хангах цогц арга хэмжээ гэж тодорхойлсон. Саналд дурдсан агуулга нь төслийн зохицуулалтад тусгагдсан тул нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй.                                                                                           |
| 11                                                                                                                                                                                               | Хуулийн төслийн 8.5.3  | Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хувийн Шатахуун түгээх станцын зохицуулалтыг нэмэх                                                                                                     | - | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төслийн 8.5.3-т гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үүргийг үйл ажиллагааны төрөл, эрсдэлийн түвшин, ажилтны тоо, объектын онцлогтой уялдуулан тогтоосон. Шатахуун түгээх станц нь шатамхай, дэлбэрэх бодистой харьцдаг өндөр эрсдэлтэй объект тул                                                                                                                                                                                |

|    |                         |                                                                                                                                                                                           |                                                                                                                                        |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|----|-------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                         |                                                                                                                                                                                           |                                                                                                                                        |                     | холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үүрэгт хамрагдана. Иймд зөвхөн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг шатахуун түгээх станцыг тусгайлан нэрлэн хуульд заах шаардлагагүй.                                                                                                                                                                                                              |
| 12 | Хуулийн төслийн 50.15   | Онцгой байдлын байгууллагын захиалгаар гадаадын их дээд сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлс болон ирэх буцах тээврийн зардлыг жилд нэг удаа төр хариуцна. | -                                                                                                                                      | Тусгагдсан.         | Саналын агуулгыг хуулийн төслийн 50.15-д тусгасан. Тодруулбал Онцгой байдлын байгууллагын захиалгаар гадаадын их, дээд сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлс болон ирэх, буцах нэг удаагийн тээврийн зардлыг төрөөс хариуцахаар тусгасан.                                                                                                                                                             |
| 13 | Хуулийн төслийн 30.1.20 | Орон нутгийн өмчид байгаа тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийг Засаг даргатай зөвшилцөн Онцгой байдлын салбар нэгж хооронд шилжүүлэх                                             | Гамшгийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн онцгой нөхцөлд шийдвэрийг шууд хэрэгжүүлэх, харин ердийн үед зөвшилцөх гэж зааглах нь зүйтэй.    | Тусгагдсан.         | Хуулийн төслийн 30.1.20-д гамшигтай тэмцэх бэлэн байдлыг хангах зорилгоор орон нутгийн өмчид байгаа тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмжийг тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн Онцгой байдлын байгууллагын салбар, нэгж хооронд шилжүүлэх, хуваарилахаар зохицуулсан. Орон нутгийн өмчийг захиран зарцуулах бүрэн эрх нь тухайн шатны Засаг даргад хадгалагдана.                                                           |
| 14 | 51.2                    | Уг заалтыг хэрэгжүүлэхэд анхаарч төсөвт суулгаж байх эсвэл хасах хэрэгжүүлэх                                                                                                              | Тухайн жилийн батлагдсан төсвийн 1 хувь түүнээс дээш хувийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах зардалд зарцуулна гэсэн нь төсвийн | Хэсэгчлэн тусгасан. | Саналын зорилгыг дэмжиж хуулийн төсөлд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тогтвортой санхүүжилтийг сайжруулах зохицуулалтыг тусгасан. Тодруулбал, хуулийн төслөөр аймаг, сум, нийслэл, дүүрэгт Гамшгийн эрсдэлийг бууруулах сан байгуулж, сангийн эх үүсвэрт энэ хуулийн 51.2-т заасан хөрөнгө, улсын болон орон нутгийн төсвийн нэмэлт санхүүжилт, зээл, тусламж, хандив болон бусад эх үүсвэрийг хамруулах, мөн сангийн хөрөнгийн |

|    |                                |                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                         |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|----|--------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                                |                                                                                                                                            | байгууллагуудад бодит байдалд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг. Уг байгууллагад маш хэрэгцээтэй чухал заалт боловч боломж байдаггүй. Учир нь төсвийн төсөлд тусгадаг батлагдаж ирдэггүй тул хэрэгжилт хангалтгүй байдаг, |                      | зарцуулалтын чиглэлийг тодорхой болгосон. Иймд саналын агуулгыг санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох замаар тусгасан                                                                                                                                                                                                                                                                                               |
| 15 | -                              | Орон нутгийн хөгжлийн сангаар худалдан авч өгдөг техник, тоног төхөөрөмжийг тодорхой стандартад нийцүүлсэн байх талаар хуулийн заалт нэмэх | -                                                                                                                                                                                                                       | Тусгах шаардлагагүй. | Аврах ажиллагааны техник, тоног төхөөрөмжийн техникийн шаардлага, стандарт, үзүүлэлтийг холбогдох стандарт, техникийн зохицуулалт болон худалдан авах ажиллагааны баримт бичгээр тогтоох боломжтой. Иймд худалдан авах ажиллагааны техникийн шаардлагыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагагүй                                                                                                                         |
| 16 | Хуулийн төслийн 32.2.1, 51.7.3 | Орон нутгийн түвшинд сайн дурын ажилтан, СӨХ, ТББ-уудын оролцоог хангах ба тэднийг сургах, урамшуулах арга хэмжээг сангаас санхүүжүүлнэ.   | Орон нутагт сайн дурын хэсэг (жишээ нь, малчид, залуучууд)-ийг идэвхжүүлэхийн тулд зөвхөн мөнгөн урамшуулал бус, тэднийг гамшгаас                                                                                       | Хэсэгчлэн тусгасан.  | Саналын үндсэн агуулгыг хуулийн төсөлд тусгасан. Тодруулбал, хуулийн төслийн 32.2.1-д гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийт, нөхөрлөл, сайн дурын ажилтан, сууц өмчлөгчдийн холбоо, төрийн бус байгууллагын оролцоог хангаж хамтран ажиллахаар, 51.7.3-т Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгийг гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг |

|                                          |                 |                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                          |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
|------------------------------------------|-----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                          |                 |                                                                                                                                                                                                             | хамгаалах анхан шатны багаж, тусгай хувцас хэрэгслээр (төслийн 3-р зүйлд заасанчлан) хангах зардлыг орон нутгийн сангаас тогтвортой санхүүжүүлэх журмыг тодорхой болгох. |                      | хангах, урамшуулах арга хэмжээнд зарцуулахаар тус тус зохицуулсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>4. Булган (2026.07.02 31/230 ОБГ)</b> |                 |                                                                                                                                                                                                             |                                                                                                                                                                          |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| 17                                       | 8.6<br>Нэмэлт   | Томоохон сүлжээ дэлгүүр, үйлдвэрлэл үйлчилгээний газрууд, Шатахуун түгээх станц, Банкны салбарууд Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг бүс орон нутгийн түвшинд боловсруулж салбар нэгжүүд дагаж мөрдөн ажиллана. | Жишээ нь: Орон нутагт сум бүрд банкны салбарт 2-3 ажилтантай байгууллага байдаг бөгөөд салбар бүр гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж ажиллахад хүндрэл үүсдэг     | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төслийн 8.6-д гамшгаас хамгаалах төлөвлөгөөг байгууллагын үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшин, байршилд үндэслэн боловсруулах зохицуулалтыг тусгасан. Байршил, эрсдэлийн нөхцөл өөр өөр салбар нэгжүүдэд нэг төлөвлөгөөг нийтлэг мөрдүүлэх нь тухайн нутаг дэвсгэрийн эрсдэлийг бүрэн тусгах боломжгүй тул салбар нэгж бүр өөрийн байршил, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах нь зүйтэй |
| 18                                       | 13.10<br>Нэмэлт | Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг аймаг, нийслэл, гамшгаас хамгаалах улсын албаны түвшинд Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, сум  | -                                                                                                                                                                        | Тусгагдсан.          | Хуулийн төслийн 13.7-д гамшгаас хамгаалах иж бүрэн болон гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургуулийг аймаг, нийслэл, гамшгаас хамгаалах улсын албаны түвшинд Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүргийн түвшинд аймаг, нийслэлийн Онцгой                                                                                                                                                             |

|    |                         |                                                                                                                                             |                                                                          |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|----|-------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                         | дүүргийн түвшинд аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллага тус тус зохион байгуулна                                                      |                                                                          |                      | байдлын байгууллага тус тус зохион байгуулахаар тодорхой зохицуулсан.                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 19 | Хуулийн төслийн 26.1.10 | Хасах                                                                                                                                       | -                                                                        | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төслийн 26.1.10-д тусгасан зохицуулалт нь гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардлагатай бүрэн эрхийг тодорхойлох зорилготой. Саналд тухайн заалтыг хасах үндэслэл, хэрэгжилтэд үүсэж буй хүндрэл, эрх зүйн зөрчлийг дурдаагүй бөгөөд уг зохицуулалтыг хасах шаардлага тогтоогдоогүй                                                            |
| 20 | Хуулийн төслийн 34.1.3  | 34.1.3 дахь хэсэгт үйл ажиллагааны чиглэл, ажилчдын тоог тодорхой болгож заах                                                               | Ингэснээр ямар байгууллага орон тооны ажилтантай байх нь тодорхой болно. | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төслийн 34.1.3-т гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан ажиллуулах эрхийг хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлог, эрсдэлийн түвшинтэй уялдуулан зохицуулсан. Харин ажилтны тоо, үйл ажиллагааны чиглэлийг хуулиар нэг бүрчлэн тогтоох нь байгууллагын төрөл, бүтэц, эрсдэлийн ялгаатай байдлыг харгалзах боломжийг хязгаарлах тул нийтлэг шалгуурыг хуулиар тогтоох шаардлагагүй |
| 21 | Хуулийн төслийн 51.7.3  | “Гамшгаас хамгаалах алба мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, урамшуулах” гэж нэмэх | -                                                                        | Тусгагдсан.          | Саналын агуулгыг хуулийн төсөлд тусгасан. Хуулийн төслийн 51.7.3-т Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгийг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, урамшуулах арга хэмжээнд зарцуулахаар тусгасан.                                                                                                          |
| 22 | 50.9                    | “30 хувиас доошгүй” гэснийг хэсгийн “40 хувиас доошгүй” гэх.                                                                                | -                                                                        | Тусгагдсан.          | Хуулийн төслийн 50.9-д тусгагдсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 83 дугаар тогтоолоор Засгийн газрын 2018 оны 380 дугаар тогтоолоор баталсан "Онцгой байдлын байгууллагын алба хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох                                                                                                                                                    |

|    |                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|----|-----------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                      | журам"-д өөрчлөлт оруулж, Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг 40 хувь болгож нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, уг тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Шадар сайд, Сангийн сайдад даалгасан.                                                                                                                                                                          |
| 23 | Хуулийн төслийн 27 <sup>1.5</sup> | “Улсын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцэд байгуулах бөгөөд түүний алба хаагчийг тус байгууллагын дарга томилж чөлөөлнө, аймгийн онцгой комиссын нарийн бичгийг аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч хавсран гүйцэтгэнэ” гэж нэмэх | Хавсран гүйцэтгэнэ гэж бичсэнээр Онцгой комиссын үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж бүх төрлийн баримт бичгийн хэрэгжилт, төлөвлөлт, гүйцэтгэлийг хариуцан ажилладаг аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч нарт хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл олгох боломж бүрдэнэ | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төслийн 27 <sup>1.5</sup> -д Улсын онцгой комиссын ажлын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтцэд ажиллуулахаар зохицуулсан. Харин аймаг, орон нутгийн Онцгой комиссын нарийн бичгийн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаалтан, түүний ажлын зохион байгуулалт нь байгууллагын бүтэц, орон тоо, албан тушаалын хуваарилалтаар шийдвэрлэх асуудал бөгөөд хуульд тодорхой албан тушаалыг нэрлэн тогтоох шаардлагагүй. |

| 5. Говь-Алтай (2026.07.03 32/233 ОБГ, аймаг, сумын засаг дарга, төрийн байгууллагуудын саналын хамт) |                        |                                                                                                                                                                 |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 24                                                                                                   | Хуулийн төслийн 4.1.26 | Ерөнхий зориулалттай болон тусгай зориулалттай гэж тусад нь нэр томьёо оруулж ялгааг нь гаргах                                                                  | - | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төслийн 4.1.26-д “гамшгаас хамгаалах алба”-ыг гамшгаас хамгаалах үйл ажиллагааг салбарын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг түшиглэн байгуулсан орон тооны бус томилгоот нэгж гэж тодорхойлсон. Харин “ерөнхий зориулалттай”, “тусгай зориулалттай” гэж ангилах нь гамшгаас хамгаалах <b>мэргэжлийн ангийн</b> чиг үүрэг, зохион байгуулалттай холбоотой ойлголт бөгөөд “гамшгаас хамгаалах алба”-ны нэр томьёоны тодорхойлолтод уг ангиллыг нэмж тусгах шаардлагагүй.        |
| 25                                                                                                   | 51.5.1 /Нэмэлт/        | Аймгийн засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн томилолт, урамшууллын зардлыг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгөөс шийдвэрлэх              | - | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төслийн 51.5-д Гамшгийн эрсдэлийг бууруулах санг байгуулах, 51.6-д сангийн эх үүсвэр, 51.7-д сангийн хөрөнгийг зарцуулах чиглэлийг тус тус тодорхойлсон. Тухайлбал, 51.7.1-д гамшгийн өмнөх үйл ажиллагаа, 51.7.2-т гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ, 51.7.3-т сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, урамшуулах арга хэмжээг санхүүжүүлэхээр заасан. Харин Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн томилолт, урамшууллыг сангаас санхүүжүүлэхээр тусгайлан заах шаардлагагүй. |
| 26                                                                                                   | Хуулийн төслийн 51.5   | Төрийн байгууллага тусгай сан байгуулах нь Төсвийн хуульд хориглосон байдаг тул ГХТХ-ийг дагаж төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсвэл Төсвийн тухай | - | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төслийн 51.5-51.9 дэх хэсгийн зохицуулалтыг тайлбарлавал, уг сан нь Засгийн газрын тусгай сан байгуулах тухай бус, аймаг, нийслэл, сум, дүүрэгт гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээг тогтвортой санхүүжүүлэх                                                                                                                                                                                                                                                                                    |

|    |    |                                                                                                                                                              |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|----|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |    | хуулийн заалт Гамшгийн эрсдлийн санг байгуулахад хамаарахгүй гэдэг байдлаар хуульд нэмэлт заалт оруулах.                                                     |   |                     | зориулалт бүхий орон нутгийн сангийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилготой юм. Сангийн эх үүсвэр, зарцуулалтын чиглэл, төлөвлөлт, үйл ажиллагааны журмыг хуульд ерөнхий байдлаар тогтоож, сангийн үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгасан нь төсвийн харилцааг Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн зохицуулалт болно.                                                                                                               |
| 27 | -  | ОБЕГ, аймгийн ОБГ-т харьяалалгүй хүн, гадаадын иргэнээс ирсэн дуудлагын дагуу сумаас ажлын хэсэг гарч ажилласан бол тус зардлыг хэн шийдвэрлэх талаар тусгах | - | Тусгасан.           | Хуулийн төслийн 34.2.12-т гамшиг, ослын шинжгүй, ахуйн дуудлагаар томилгоот шуурхай бүлгийг ажиллуулсан тохиолдолд холбогдох зардлыг хариуцахаар, 37.2.10-т иргэн өөрийн хүсэлтээр томилгоот шуурхай бүлгийг ажиллуулсан тохиолдолд зардлыг хариуцан төлөхөөр, 51.11-т гамшиг, ослын шинжгүй ахуйн дуудлагаар ажилласан томилгоот шуурхай бүлгийн зардлыг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд хариуцахаар тус тус зохицуулсан.                                                                                                                     |
| 28 | 51 | Гамшгийн эрсдлийн санхүүжилт бүх шатны төсөвт хасахгүйгээр хуулинд заасан хувь хэмжээгээр төсөвлөх                                                           | - | Хэсэгчлэн тусгасан. | 51.5-д аймаг, сум, нийслэл, дүүрэг гамшгийн эрсдэлийг бууруулах сантай байхаар, 51.6-д уг сангийн эх үүсвэрт 51.2-т заасан хөрөнгө, улсын болон орон нутгийн төсвийн нэмэлт санхүүжилт, зээл, тусламж, хандив болон бусад эх үүсвэрийг хамруулахаар тусгасан.<br>Гэвч 51.2-т заасан төсвийн хувь хэмжээг төсөвт “хасахгүйгээр” тусгах, өөрөөр хэлбэл тухайн хөрөнгийг бусад зориулалтаар бууруулахгүй байх тусгай зохицуулалтыг төсөлд нэмж тусгаагүй. Иймд саналын зорилгыг санхүүжилтийн тусгай сангийн тогтолцоогоор хэсэгчлэн тусгасан гэж үзэв. |
| 29 | 19 | Дайчилж буй хувийн техник, эд хөрөнгийн                                                                                                                      | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 19.5-д иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшлийн эд                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |

|                                                                                                                        |                          |                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                        |                          | тариф, үнэлгээг баталсан журам гаргах                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                |                     | хөрөнгө, бараа материал, газар, барилга байгууламжийг дайчилсан тохиолдолд холбогдох зардлыг 20.4-т заасан журмын дагуу төрөөс олгохоор тусгасан.                                                                                                                                                                               |
| 30                                                                                                                     | Хуулийн төслийн 51.8     | Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангийн 5-аас доошгүй хувийг аймаг, нийслэл, дүүргийн хувьд тухайн шатны гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн шийдвэрээр, сумын хувьд тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр төлөвлөж, зарцуулна. | Мэргэжлийн ангид хэрэгцээтэй тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл авах, гамшиг осол хүн малын халдварт өвчин гарахад пост ажиллуулахад гэр майхан, ариутгалын тоног төхөөрөмж шаардагдахад санхүүжилт байдаггүй. Засаг даргын нөөц хөрөнгө хаана нь ч хүрэлцдэггүй. | Хэсэгчлэн тусгасан. | 51.5-д аймаг, сум, нийслэл, дүүрэг Гамшгийн эрсдэлийг бууруулах сантай байхаар, 51.6-д сангийн эх үүсвэрийг, 51.7-д сангийн хөрөнгийг гамшгийн өмнөх үйл ажиллагаа, гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ, сайн дурын хэсэг, сайн дурын ажилтны бэлэн байдлыг хангах зэрэгт зарцуулахаар тусгасан. |
| <b>6. Говьсүмбэр (2026.07.06 33/157)</b>                                                                               |                          |                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| Саналгүй                                                                                                               |                          |                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| <b>7. Дархан-Уул (2026.07.08 34/241 ОБГ, Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумдын Засаг дарга, ИТХ-ын саналын хамт)</b> |                          |                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
| 31                                                                                                                     | 34 дүгээр зүйлд /Нэмэлт/ | Тухайн хуулийн этгээдийн үүрэгт: холбогдох хууль тогтоомж, гамшгаас хамгаалах тухай хууль, дүрэм журам, баримт бичгийн шаардлагыг биелүүлэх, гамшгийн асуудлыг хариуцсан албан тушаалтныг томилох;                                                                                      | Гамшгын эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах болон гамшигтай холбогдолтой                                                                                                                                                     | Хэсэгчлэн тусгасан. | Саналын гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байх тухай агуулга нь одоо мөрдөж буй хуулийн 34.2.1, 34.2.5-д аль хэдийн тусгагдсан бөгөөд хуулийн төсөлд эдгээр зохицуулалтыг боловсронгуй болгож, төлөвлөгөө болон эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээг тодорхой болгосон.                        |

|    |                          |                                                                                                                               |                                                                                                                                                                                                     |                      |                                                                                                                                                                                                              |
|----|--------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                          |                                                                                                                               | байгууллагад тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд гамшгийн асуудал хариуцсан бие даасан мэргэжилтэн шаардлагатай                                                                                    |                      | Хуулийн төслийн 34.1.3-т нийтийн үйлдвэр, үйлчилгээ, онц чухал объект, томоохон барилга байгууламж эзэмшдэг/өмчилдөг ААН, байгууллага гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, нэгж томилно. |
| 32 | 30 дугаар зүйлд /шинээр/ | Барилга байгууламжийн байршлыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж мэргэжлийн дүгнэлт гаргах                           | Барилга байгууламж болон орон сууцны хорооллын үерийн хамгаалалтын ил болон далд суваг шуудуу, далан зам гүүрний ус зайлуулах зориулалтын инженерийн байгууламжид хяналт тавьж дүгнэлт санал гаргах | Тусгах шаардлагагүй. | Гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагчийн эрх, үүргийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулна.                                                                                                 |
| 33 |                          | Барилга байгууламжийг ашиглалтад авах комиссын бүрэлдэхүүнд оролцох, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд санал, дүгнэлт гаргах |                                                                                                                                                                                                     |                      |                                                                                                                                                                                                              |
| 34 |                          | Барилга байгууламжийн зураг төсөл гамшиг ослоос хамгаалагдсан эсэхэд магадлал хийж дүгнэлт гаргах                             | Аймаг, сумдын нутаг дэвсгэр дэх үерийн уснаас хамгаалах далан суваг шуудуу ус өнгөрүүлэх зориулалтын ил ба далд                                                                                     |                      |                                                                                                                                                                                                              |

|    |   |                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                            |                        |                                                                                                                                                                                                 |
|----|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |   |                                                                                                                                                                                                                                                       | инженерийн<br>байгууламжийн<br>зураг төсөлд<br>хяналт тавьж<br>дүгнэлт гаргахад<br>Гамшгаас<br>хамгаалах<br>улсын хяналтын<br>байцаагчийн<br>санал<br>дүгнэлтийг<br>тусгах |                        |                                                                                                                                                                                                 |
| 35 |   | Гамшиг осол, гал түймрийн<br>үед шалтгаан нөхцөлийг<br>тогтоох зорилгоор<br>/гүйцэтгэх ажил/ зохион<br>байгуулах мэргэшсэн<br>албан тушаалтанг бий<br>болгох, томилох                                                                                 | Гамшиг, осол, ой<br>хээрийн түймэр,<br>хүн, малын гоц<br>халдварт өвчин<br>зэргийг<br>шалтгаан<br>нөхцөлийг<br>тогтоох,<br>илрүүлэх,<br>таслан зогсоох                     |                        |                                                                                                                                                                                                 |
| 36 | - | Гамшгийн үед дайчлагдан<br>ажиллаж байгаа хувийн<br>хэвшлийн байгууллагын<br>албан хаагчдын цалин<br>урамшууллын асуудлыг<br>журамлан шийдвэрлэх                                                                                                      | -                                                                                                                                                                          | Хэсэгчлэн<br>тусгасан. | Хуулийн төслийн 34.2.11-т гамшгийн хор<br>уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн<br>босгох ажиллагаанд дайчлагдсан ажилтны<br>ажлын байрыг хэвээр хадгалж, цалин<br>хөлсийг олгоно гэж тусгасан. |
| 37 | - | Гамшгаас хамгаалах,<br>эрсдэлийг бууруулах арга<br>хэмжээний зардалд аймаг,<br>сум, нийслэл, дүүрэг,<br>төрийн байгууллага тухайн<br>жилийн төсвийнхөө 1.0<br>хувиас доошгүйг<br>зарцуулахаар тооцон<br>төсөвт суудаггүй тул түүнд<br>анхаарч ажиллах | -                                                                                                                                                                          | Тусгасан.              | Одоогийн төслийн 51.6.1, 51.7 нь 51.2-т<br>заасан хөрөнгийг Гамшгийн эрсдэлийг<br>бууруулах сангийн эх үүсвэр,<br>зарцуулалттай холбож өгсөн.                                                   |

|    |   |                                                                                                                                                                                                                                                                                                     |   |                      |                                                                                                                                                                                           |
|----|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 38 | - | Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, стратегийн команд штабын сургуульд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нар болон ажлын албыг хамруулах                                                                                                                                                    | - | Тусгасан             | Хуулийн төслийн 13.6-д төрийн болон нутгийн захиргааны байгууллага, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, ААН-ийн удирдлага, ажилтан, алба хаагч, иргэнийг хамруулсан. |
| 39 | - | Сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоонд Гамшгийн асуудал хариуцсан албан хаагчийн орон тоо байхгүй, бусад мэргэжилтэнд давхар хариуцуулан хийлгэж, ажлын ачааллыг нэмэгдүүлэх асуудал гардаг. Иймд сумын бүтэц орон тоонд Гамшгийн асуудал хариуцсан албан хаагчийн орон тоог бий болгох | - | Тусгасан             | 42.10-т онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын ЗДТГ-т онцгой байдлын байгууллагын нэг алба хаагч томилохоор тусгасан                                                           |
| 40 | - | Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу сайн дурын бүлгийг томилохоор заасан байдаг. Гэвч сайн дурын бүлгийг гамшгийн үед буюу цаг тухай бүрд бэлэн байдалд ажиллуулахад практик дээр хэрэгждэггүй бөгөөд уг сайн дурын бүлгийг ажиллуулах урамшуулал олгох                                    | - | Тусгасан.            | 51.7.3 – сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, урамшуулах арга хэмжээг санхүүжүүлнэ.                                                                |
| 41 | - | Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг томилоход төр, төсвийн байгууллагын албан                                                                                                                                                                                                 | - | Тусгах шаардлагагүй. | Эмэгтэй албан хаагч давамгайлж байгаа гэх нөхцөл байдлыг үндэслэн мэргэжлийн ангийн хүний нөөцийн тоог хуулиар бууруулах шаардлагагүй                                                     |

|    |   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                     |           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|----|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|-----------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |   | хаагчдыг дайчлан томилдог. Гэвч сүүлийн жилүүдэд төрийн байгууллагын хүйсийн тэнцвэрт байдал алдагдаж эмэгтэй албан хаагч давамгайлсан бөгөөд мэргэжлийн ангид томилогдсон албан хаагчдын 80 хувь эмэгтэй албан хаагч байдаг. Гамшгийн эрсдэлийн үед дайчлан ажиллахад эрэгтэй албан хаагч дутмаг байдаг тул мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний ажиллах хүн хүчний тоог багасгах. |                                     |           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| 42 | - | Гамшгийн үед ажиллахад хүн хүч болон техник хэрэгсэл, санхүү болон бусад нөөцийн их шаардлага гардаг. Иймд хувийн хэвшлийн байгууллагуудыг дайчлан оролцуулах, шаардагдах техник хэрэгсэл, хүн хүч бусад нөөц хэрэгслээр хангах асуудлыг тусгах                                                                                                                                | -                                   | Тусгасан. | Хуулийн төсөлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох, шаардлагатай тохиолдолд хүч хэрэгсэл, эд хөрөнгийг дайчлан гаргах, дайчилсан эд хөрөнгө, барилга байгууламжтай холбоотой зардлыг төрөөс нөхөн олгох эрх зүйн зохицуулалтыг тусгасан.<br>Хуулийн төслийн 19.1 – шаардлагатай үед хүч хэрэгслийг дайчлан гаргана. 4.1.13 – хүч хэрэгсэл дайчлан гаргахыг ААН, иргэнийг татан оролцуулах, эд хөрөнгө, газар ашиглах гэж тодорхойлсон. 19.4–19.5 – эд хөрөнгө, барилга байгууламжийг ашиглах, дайчилсан тохиолдолд зардлыг төрөөс олгох. |
| 43 | - | Сумдад орон нутгийн хамгаалалт болон гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон                                                                                                                                                                                                                                                                                                 | Сумдад гамшгаас хамгаалах чиглэлээр | Тусгасан. | 42.10-т онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын ЗДТГ-т онцгой байдлын байгууллагын нэг алба хаагч томилохоор тусгасан                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |

|    |   |                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |                     |                                                                         |
|----|---|----------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|-------------------------------------------------------------------------|
|    |   | тооны мэргэжилтэнг ЗДТГ-ын бүтэц орон тоонд нэмж тусгаж ажиллуулах шаардлагатай байна. | хариуцсан нэгж, албан тушаалтан байдаггүй. Үүнээс болоод улсын болон аймгийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах чиглэлээр ирсэн үүрэг даалгаврын хэрэгжилт, ажил үүргийг бусад ажил мэргэжил хариуцсан албан хаагчид дээр хуваарилан ажил үүргийг хэрэгжүүлж, биелэлтийг гаргуулан тайлагнадаг. Энэ нь зарим тохиолдолд гамшгаас хамгаалах чиглэлийн ажил, үүргийн төлөвлөлт, гүйцэтгэл орхигдох гол дутагдал болж байна. |                     |                                                                         |
| 44 | - | Гамшгаас хамгаалах тухай хуулинд иргэдийг                                              | Сүүлийн үед мал, амьтны гоц                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Хэсэгчлэн тусгасан. | Иргэний үүрэгтэй холбоотой 37.2.6 – гамшиг, аюулын тухай мэдээлэл болон |

|                                                                                    |                          |                                                                                                                                                                                                                          |                                                                        |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|------------------------------------------------------------------------------------|--------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------|----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                    |                          | хариуцлагажуулах талаар заалт оруулах                                                                                                                                                                                    | халдварт өвчин гаднаас, өөр аймаг, сумдаас тээвэрлэгдэн орж ирж байна. |                      | эрсдэлтэй нөхцөлийг холбогдох байгууллагад шуурхай, үнэн зөв мэдээлэх үүрэг бий. Гэхдээ Дархан-Уулын саналд дурдсан мал, амьтны гоц халдварт өвчин тээвэрлэхтэй холбоотой тусгай хариуцлага тусгагдаагүй.                                                                                                                                                                                                                                                                     |
| <b>8. Дорноговь (2026.07.07 36/183)</b>                                            |                          |                                                                                                                                                                                                                          |                                                                        |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| Саналгүй                                                                           |                          |                                                                                                                                                                                                                          |                                                                        |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| <b>9. Дорнод (2026.07.07 35/281 Нутгийн захиргаа, ЗДТГ, иргэдийн саналын хамт)</b> |                          |                                                                                                                                                                                                                          |                                                                        |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
| 45                                                                                 | 32 дугаар зүйлд /Нэмэлт/ | "Бүх шатны Засаг дарга нь нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор багаж хэрэгслээр хангах, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж, худалдан авч болно" | -                                                                      | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төслийн 32.1.15-д тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгөд хор уршиг учруулж болзошгүй орчны эрсдэлтэй нөхцөлийг арилгах арга хэмжээ авах чиг үүргийг Засаг даргад тусгасан боловч багаж, техник хэрэгслээр хангах, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж, худалдан авахтай холбоотой тусгай зохицуулалт хуулийн төсөлд тусгагдаагүй                                                                  |
| 46                                                                                 |                          | "Гамшгийн үед иргэд болон тээврийн хэрэгслийг дайчлан ажиллуулах тохиолдолд тухайн иргэн аж ахуйн нэгжид урамшуулал олгох"                                                                                               | -                                                                      | Хэсэгчлэн тусгасан.  | Хуулийн төслийн 19.1-д гамшиг, аюулын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргахаар, 4.1.13-т хүч хэрэгсэл дайчлан гаргах хүрээнд иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах, тэдгээрийн эд хөрөнгө, газрыг ашиглахаар тусгасан. Мөн 19.5-д дайчилсан эд хөрөнгө, бараа материал, газар, барилга байгууламжтай холбоотой зардлыг төрөөс олгохоор зохицуулсан боловч дайчлагдан ажилласан иргэн, аж ахуйн нэгжид урамшуулал олгох талаар тусгайлан зохицуулаагүй |
| 47                                                                                 |                          | "Гамшгаас хамгаалах тусгай болон ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдал, хувцас хэрэгсэл, техник,                                                                                     | -                                                                      | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төсөлд мэргэжлийн ангийг сургалт, дадлагад хамруулах, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэхтэй холбоотой зохицуулалт байгаа боловч мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал, хувцас хэрэгсэл, техник, багаж хэрэгслээр                                                                                                                                                                                                                                                 |

|    |                                                                                                                                                                                                                                                                                                                                           |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                   |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    | багаж хэрэгслээр хангаагүй тухайн шатны Засаг даргад хариуцлага тооцох"                                                                                                                                                                                                                                                                   |   |                      | хангаагүй Засаг даргад хариуцлага хүлээлгэх тусгай зохицуулалт байхгүй.                                                                                                                                                                                                                           |
| 48 | "Гамшгаас хамгаалах тусгай болон ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд томилогдсон ажилтан, алба хаагч, иргэн нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох"                                                                                                                                                          | - | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төсөлд мэргэжлийн ангийн ажилтан, алба хаагч, иргэний үүргийг хэрэгжүүлэх талаар зохицуулалт байгаа боловч үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тусгай зохицуулалт оруулаагүй.                                                                                            |
| 49 | "Алслагдсан суманд өөр аймаг, сумаас томилогдон үүрэг гүйцэтгэж байгаа Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг сумын Засаг дарга орон сууцаар хангах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх"                                                                                                                             | - | Хэсэгчлэн тусгасан.  | Хуулийн төслийн 42.10-д онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын Тамгын газарт онцгой байдлын байгууллагын нэг алба хаагчийг томилж ажиллуулахаар, 32.1.13-д уг алба хаагчид орон байрны нөхцөлөөр хангах агуулгыг нэмэхээр тусгасан.                                       |
| 50 | "Бүх шатны Засаг дарга Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор Онцгой байдлын байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгоно" | - | Тусгах шаардлагагүй. | Хуулийн төсөлд алба хаагчийн цалин, эрүүл мэнд, хүнс, эдийн хангалт зэрэг асуудлыг зохицуулсан 50.15–50.18 дахь хэсгүүд шинээр туссан боловч өөр аймаг, хотоос томилогдон ажиллахтай холбоотой уналга, ачаа тээш, зам хоног болон гэр бүлийн гишүүдийн тээврийн зардал гэсэн зохицуулалт ороогүй. |
| 51 | "Бүх шатны Засаг дарга нь гамшгаас хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх                                                                                                                                                                                                                                                                      | - | Хэсэгчлэн тусгасан.  | Хуулийн төслийн 32.1.13-д энэ хуулийн 42.10-д заасан алба хаагчийг орон байрны нөхцөлөөр хангах агуулгыг тусгасан боловч                                                                                                                                                                          |

|    |                        |                                                                                                                                                                                                                                                                                             |   |                      |                                                                                                                                                                                                                            |
|----|------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                        | нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэр дэх онцгой байдлын байгууллагын алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ” |   |                      | хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, алба хаагч болон түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх, холбогдох зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх талаар тусгаагүй.                                         |
| 52 |                        | "Гамшгаас хамгаалах тусгай болон ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн гал түймэр, гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд үүргээ гүйцэтгэсэн ажилтан, алба хаагч, иргэнд томилолт, урамшуулал олгох"                                              | - | Тусгах шаардлагагүй. | ОБЕГ-ын даргын 2024 оны А/379 дугаар тушаалаар батлагдсан Мэргэжлийн ангийн дүрмийн 5.3.16-д “гамшгийн голомтод ажилласан ажилтан алба хаагчид томилолт, урамшуулал олгох;” зохицуулалт туссан.                            |
| 53 | Хуулийн төслийн 42.10  | "Тухайн суманд томилогдон ажиллах алба хаагчийн ажиллах нөхцөл бололцоог сумын Засаг дарга хариуцан” гэж тус тус өөрчлөн найруулах.                                                                                                                                                         | - | Тусгасан.            | Хуулийн төсөлд 42.10-ыг шинээр тусгаж, ОБ-ын салбар, нэгжгүй сумын ЗДТГ-т ОБ-ын нэг алба хаагч томилж ажиллуулахаар зохицуулсан. Мөн 32.1.13-д уг алба хаагчийг орон байрны нөхцөлөөр хангахтай холбоотой нэмэлт оруулсан. |
| 54 | Хуулийн төслийн 34.1.3 | Сумын Засаг даргын тамгын газарт гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан томилж ажиллуулах гэсэн заалтыг нэмэлтээр оруулах                                                                                                                                                  | - |                      |                                                                                                                                                                                                                            |

|                                             |                        |                                                                                                          |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|---------------------------------------------|------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 55                                          | Хуулийн төслийн 51.7.3 | Дайчлагдан ажиллаж байгаа хувийн автомашинтай иргэнийг урамшуулах                                        | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 51.7.3-т гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, урамшуулах арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгасан                                                                                                                                                                                                                                                  |
| <b>10. Дундговь (2026.07.07 37/190 ОБГ)</b> |                        |                                                                                                          |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| 56                                          | Хуулийн төслийн 8.5.3  | Үйлдвэр үйлчилгээ эрхлэгч ажилтан алба хаагчдын тоог заах хамгийн бага утга                              | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 8.5.3-т Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5.1.1-д заасан бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах шаардлагаас чөлөөлөхөөр тусгасан. Гэвч ажилтан, алба хаагчдын тооны доод босгыг Гамшгаас хамгаалах тухай хуульд тусгайлан заагаагүй бөгөөд бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн ангиллыг холбогдох хуулийн зохицуулалтаар тодорхойлохоор байна. |
| 57                                          | Хуулийн төслийн 34.1.3 | Аж ахуй нэгж байгууллага хүний тоо заах                                                                  | - | Хэсэгчлэн тусгасан. | Төслийн 34.1.3-т нийтийн үйлдвэр, үйлчилгээ, онц чухал объект, томоохон барилга байгууламж эзэмшдэг, өмчилдөг аж ахуйн нэгж, байгууллага гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, нэгж томилж ажиллуулахаар заасан.<br>Гэвч уг заалтад ажилтны тооны босго, эсхүл үйл ажиллагааны тодорхой төрөл бүрээр ямар тооны ажилтантай этгээд орон тооны ажилтан, нэгжтэй байх талаар шалгуур тогтоогоогүй.        |
| 58                                          | Хуулийн төслийн 42.10  | Сумын засаг даргын тамгын газарт Онцгой байдлын асуудал эрхэлсэн орон тооны 1 ажилтанг томилж ажиллуулах | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 42.10-д Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын Тамгын газарт Онцгой байдлын байгууллагын нэг алба хаагчийг томилж ажиллуулахаар тусгасан.                                                                                                                                                                                                                                         |
| 59                                          | Хуулийн төслийн 7.1    | гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг ямар байгууллагад, нарийвчилсан үнэлгээг                             | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 7.1-д гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх этгээдийг, 7.5-д нарийвчилсан үнэлгээнд Онцгой байдлын байгууллага                                                                                                                                                                                                                                                                    |

|                                                                                      |                                   |                                                                                                                               |                                                                                                                                                                                                 |            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
|--------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                      |                                   | ямар байгууллагад хийх талаар тодорхой болгох                                                                                 |                                                                                                                                                                                                 |            | хяналт тавихыг тусгасан. Харин ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг тус тус ямар байгууллага, хуулийн этгээд гүйцэтгэхийг 7.1-д тусгайлан заагаагүй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>11. Завхан</b> (2026.07.06 38/232 ОБГ, сумдын Засаг дарга, иргэдийн саналын хамт) |                                   |                                                                                                                               |                                                                                                                                                                                                 |            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| 60                                                                                   | Хуулийн төслийн 27 <sup>1.4</sup> | Сумын Засаг даргын нөөц хөрөнгө томилолт урамшуулал олгоход хүрэлцээгүй байдаг учраас орон нутгийн хөгжлийн сангаас гаргуулах | -                                                                                                                                                                                               | Тусгаагүй. | Хуулийн төслийн 27 <sup>1.4</sup> -т Онцгой комиссын шуурхай штаб, ажлын хэсгийн үйл ажиллагааны зардлыг орон нутагт Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэх зохицуулалтыг хэвээр үлдээсэн. Завхан аймгийн саналд заасан нөөц хөрөнгө хүрэлцээгүй тохиолдолд Орон нутгийн хөгжлийн сангаас томилолт, урамшууллын зардлыг санхүүжүүлэх асуудлыг төсөлд тусгаагүй. Түүнчлэн Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6, 4.7-д ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зориулалтыг хязгаарласан бөгөөд 4.7.6-д байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшууллыг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхийг хориглосон. |
| 61                                                                                   | 50.11                             | Аймгийн төв болон бусад суманд гэж оруулах                                                                                    | Аймгийн төвийн анги салбарын алба хаагчдын ачаалал аймгийн төвөөс бусад сумын анги салбарын алба хаагчдын ачааллаас илүү байдаг, мөн Улаанбаатар хотоос алслагдсан аймгуудын хүнс, ахуйн бараа, | Тусгаагүй. | Одоо мөрдөж буй хуулийн 50.11-д аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажилласан Онцгой байдлын байгууллагын алба хаагчид мөнгөн урамшуулал олгохоор зохицуулсан. Хуулийн төсөлд 50.11-д нэмэлт, өөрчлөлт оруулаагүй бөгөөд 50.15–50.18-д өөр агуулгатай нэмэлт зохицуулалт тусгасан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |

|                                                                                                                 |            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------|------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                 |            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | шатахуунд ачаа тээврийн хөлс нэмэгдэж хүнс, ахуйн бараа, шатахууныг өндөр өртөгтэйгөөр худалдан авч хэрэглэдэг |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>12. Орхон</b> (2026.07.08 39/183 ЗДТГ, Онцгой комисс, төрийн байгууллага, сумдын Засаг даргын саналын хамт ) |            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| 62                                                                                                              | 7.7        | Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр 11.8-д заасан гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаантай олгох бөгөөд тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмаар зохицуулж, эрсдэлийн үнэлгээний мэргэжилтнүүдийг адистатчилах | -                                                                                                              | Тусгаагүй.          | Хуулийн төслийн 7.1-д гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэх, 7.5-д нарийвчилсан үнэлгээнд Онцгой байдлын байгууллага хяналт тавих зохицуулалт тусгасан боловч нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаатай олгох, уг зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон эрсдэлийн үнэлгээний мэргэжилтнийг адистатчилах асуудлыг хуулийн төсөлд тусгаагүй.                                      |
| 63                                                                                                              | -<br>Нэмэх | Орон нутгийн нутаг дэвсгэрийн газар дээр барилга байгууламж барьж байгаа хуулийн этгээд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэж, барилгын зураг төсөлд магадлал хийлгэх                                                                                                                                                                                | -                                                                                                              | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 7.1-д хуулийн этгээд гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэхээр нийтлэг үүрэг тогтоосон нь барилга байгууламж барьж байгаа хуулийн этгээдэд хамаарна. Харин барилга байгууламж барьж байгаа хуулийн этгээдэд уг шаардлагыг тусгайлан тогтоож, барилгын зураг төсөлд магадлал хийлгэх асуудлыг хуулийн төсөлд тусгаагүй. Барилгын зураг төсөл, магадлалтай холбоотой харилцааг Барилгын тухай хуулиар тусгайлан зохицуулсан тул |

|    |                       |                                                                                                                                                                                                                                                                                                                          |   |                     |                                                                                                                                                                                                                                      |
|----|-----------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                       |                                                                                                                                                                                                                                                                                                                          |   |                     | Гамшгаас хамгаалах тухай хуульд давхардуулан зохицуулах шаардлагагүй                                                                                                                                                                 |
| 64 | -<br>Нэмэх            | Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль болон их, дээд сургуулийн бүх түвшинд: <ul style="list-style-type: none"> <li>- Газар хөдлөлт</li> <li>- Үер</li> <li>- Гал түймэр, ой хээрийн түймэр</li> <li>- Анхны тусламж, нүүлгэн шилжүүлэлт зэрэг сургалтыг үндсэн хөтөлбөрт тусгах</li> </ul>           | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 13.3.6-д сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын байгууллагад суралцагчийн гамшгаас хамгаалах сургалтыг тухайн шатны боловсролын байгууллага зохион байгуулахаар тусгасан. |
| 65 | 4 дүгээр зүйлд Нэмэлт | “Гамшгаас хамгаалах улсын хяналт” гэж гамшгаас хамгаалах хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хангах, гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд хяналт тавьж хэрэгжүүлэхийг | - | Тусгаагүй.          | Хуулийн төслийн 12.1-д гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх субъект, 12.3-т гамшгаас хамгаалах хяналтын улсын ерөнхий байцаагчийн статус, 12.4-т хяналтын хамрах хүрээг тус тус тодорхойлсон.                                     |
| 66 |                       | “Ослын хор уршгийг арилгах” гэж энэ хуулийн 4.1.3-т заасан үр дагаврыг зогсоох, бууруулах, хохирол багатай давахад чиглэсэн хойшлуулшгүй арга хэмжээг                                                                                                                                                                    | - | Тусгаагүй.          | Хуулийн төслийн 4.1.3-т “осол”-ын тодорхойлолтыг тусгасан боловч “ослын хор уршгийг арилгах” гэсэн нэр томъёог 4 дүгээр зүйлд шинээр тодорхойлоогүй.                                                                                 |

|                                                                                      |             |                                                                                                                                                                                                                                                                                                                         |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|--------------------------------------------------------------------------------------|-------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 67                                                                                   | 42.4.1      | Энэ хуулийн 42.4-т заасан төрийн өмчит онц чухал болон стратегийн зориулалттай үйлдвэр, үйлчилгээний байгууллагын харьяа нэгжийн үйл ажиллагааны бүх зардал болон ажилтан, алба хаагчдын нийгмийн асуудал, шагнал, цалин, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмжийг үндсэн ажилтны нэгэн адил тухайн байгууллага бүрэн хариуцах; | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 3 дугаар зүйлээр 42 дугаар зүйлийн 42.4.1 дэх заалтын “нэгжийн” гэсний дараа “хөрөнгө оруулалтын болон” гэж нэмсэн. Харин саналд дурдсан тухайн нэгжийн үйл ажиллагааны бүх зардал, ажилтан, алба хаагчдын нийгмийн асуудал, шагнал, цалин, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмжийг үндсэн ажилтны нэгэн адил тухайн байгууллага бүрэн хариуцах зохицуулалтыг бүхэлд нь тусгаагүй.                                              |
| 68                                                                                   | -<br>Нэмэлт | Химийн хортой болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үеийн ажиллагаатай холбоотой гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагч хяналт тавьж, баталгаажуулах                                                                            | - | Тусгаагүй.          | Хуулийн төслийн 4.1.3-т химийн хорт бодис алдагдахыг ослын нэг хэлбэрт хамруулсан бөгөөд 12.4-т гамшгаас хамгаалах болон аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагч хяналт тавихаар ерөнхий зохицуулалт тусгасан.                                                                                                                                                                       |
| <b>13. Өвөрхангай (2026.07.07 40/169 ОБГ, ИТХ, сумдын Засаг даргын саналын хамт)</b> |             |                                                                                                                                                                                                                                                                                                                         |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 69                                                                                   | 12.2        | Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг хэрэгжүүлээгүй, хэрэгжүүлэхээс татгалзсан Төрийн болон албан байгууллага, аж ахуй нэгж, хуулийн этгээд, иргэнд хуулийн хариуцлага тооцдог зүйл заалтыг тодорхой болгох                                                                              | - | Тусгасан.           | Саналын агуулгыг Гамшгаас хамгаалах тухай хуульд бус, дагалдах Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан. Тухайлбал, Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн, хуульд хүлээсэн үүргээ биелүүлээгүй, улсын байцаагчийн шийдвэр, шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан. |

|    |             |                                                                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |            |                                                                                                                                                                                                                                                                                                      |
|----|-------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 70 | 51.2        | Монгол Улсын төсвийн болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээнд хөрөнгө тусгах тухай хуулийн заалтыг мөн оруулж, уялдуулах шаардлага байна. Иймд заалтын тухайн төрийн байгууллагын агентлагын дарга, сайд нар нь тухай төсвийг төсөвт нэмэлтээр суулгаж өгөх | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйл 51.2-т Гамшгаас хамгаалах, эрсдэлийн бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухай жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухай жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлыг 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна гэж заасан | Тусгаагүй. | Саналд дурдсан санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хуулийн төсөлд аймаг, сум, нийслэл, дүүрэгт Гамшгийн эрсдэлийг бууруулах сан байгуулах, уг сангийн эх үүсвэр, зарцуулалт, төлөвлөлтийг 51.5–51.8-д тусгайлан зохицуулсан.                                                                 |
| 71 | -<br>Нэмэлт | Сумдын Засаг даргын Тамгын газрын даргад Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлсний нэмэгдлийг олгоно гэж тусгах                                                                                                                                                                                            | -                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Тусгаагүй. | Сумын Засаг даргын Тамгын газрын даргад гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлсний төлөө тусгай нэмэгдэл олгох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаагүй. Харин сумын түвшинд гамшгаас хамгаалах чиг үүргийн хэрэгжилтийг бэхжүүлэх зорилгоор Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй |

|    |             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |   |                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|----|-------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|----------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |   |                      | сумын ЗДТГ-т Онцгой байдлын байгууллагын нэг алба хаагч томилж ажиллуулах зохицуулалтыг 42.10-д тусгасан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
| 72 | 50.8        | Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын ажилласан жилийг харгалзан мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 5 дээш жил ажилласан алба хаагч 3 дугаар зэрэг, 10 дээш жил ажилласан алба хаагч 2 дугаар зэрэг, 15 дээш жил ажилласан алба хаагч 1 дүгээр зэргий нэмэгдлийг олгоно гэж тусгах;                                                                                                                               | - | Тусгах шаардлагагүй. | Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн мэргэшлийн зэрэг, түүнд олгох нэмэгдлийг зөвхөн ажилласан жилээр нь автоматаар тогтоож болохгүй. Алба хаагчийн мэргэшлийн ур чадвар, ажлын гүйцэтгэл, мэргэшлийн шалгууртай уялдах шаардлагатай.                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| 73 | -<br>Нэмэлт | Гамшгаас хамгаалах тухай хуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүлж байхаар тусгасан. Тус зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төсөв мөнгийг зарцуулахад хууль эрх зүйн акт Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад байдаггүй, аймгийн Засаг даргын захирамжаар хөрөнгө гарган төлөвлөгөөг хэрэгжүүлдэг. Иймд гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд | - | Хэсэгчлэн тусгасан.  | Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүлэхээр хуульд нэгэнт зохицуулсан бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгийг зөвлөлийн дарга дангаар захиран зарцуулах эрх олгох бус, тухайн шатны гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн шийдвэрээр төлөвлөж, зарцуулахаар хуулийн төсөлд тусгасан. Энэ нь төсөв, хөрөнгийн зарцуулалтыг нэг албан тушаалтны бүрэн эрхэд төвлөрүүлэхгүйгээр хамтын шийдвэрт үндэслүүлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхтэй уялдуулах зорилготой. |

|                                          |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
|------------------------------------------|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                          |    | шаардлагатай төсвийг тус зөвлөлөлийн дарга төсөв гарган хэрэгжүүлэх хууль эрх зүйн актыг гамшгаас хамгаалах хуулинд тусгаж өгөх;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>14. Өмнөговь (2026.07.09 41/301)</b>  |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| Саналгүй                                 |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>15. Сүхбаатар (2026.07.22 43/206)</b> |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| Саналгүй                                 |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| <b>16. Сэлэнгэ (2026.07.21 31/260 )</b>  |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| 74                                       | 12 | <p>1. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрхийг зүйлчилж оруулах, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналтын тухай хууль тогтоомжид заасан бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.</p> <p>1.1. Хот төлөвлөлт, шинээр суурьшлын бүс байгуулахад гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч бүс нутгийн гамшиг, аюулт үзэгдлийн давтамж зэргийг үндэслэн дүгнэлт гаргах,</p> <p>1.2. Инженерийн барилга байгууламжийн байршлыг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж зөвлөмж гаргах, шаардлагатай тохиолдолд татгалзах, ажиллагааг зогсоох,</p> | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 12.1-д гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх субъект, 12.3-т улсын ерөнхий байцаагчийн статус, 12.4-т хяналтын хамрах хүрээг тус тус тодорхойлсон. Харин саналд дурдсан хот төлөвлөлт, инженерийн барилга байгууламжийн байршил, зураг төсөл, ашиглалтад оруулах болон “Аюулгүйн нөөц”-ийн бэлэн байдалтай холбоотой нарийвчилсан бүрэн эрхийг хуулийн төсөлд тусгайлан тогтоогоогүй. Эдгээрийн зарим нь барилгын болон салбарын тусгай хууль тогтоомж, төрийн хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулагдах тул гамшгаас хамгаалах тухай хуульд бүх бүрэн эрхийг давхарлан нэг бүрчлэн тогтоох шаардлагагүй. |

|  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |  |  |  |
|--|--|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|--|
|  |  | <p>1.3. Инженерийн барилга байгууламжийн зураг төсөл аюулт үзэгдлээс хамгаалах төлөвлөлт хийгдсэн эсэх талаар гаргасан дүгнэлт болон магадлалд хяналт хийж шийдвэр гаргах,</p> <p>1.4. Инженерийн барилга байгууламжийг барих, ашиглах явцад аюулт үзэгдлээс хамгаалах төлөвлөлт хийгдсэн эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах,</p> <p>1.5 .Инженерийн барилга байгууламжийг ашиглалтад авах улсын комиссын -т бүрэлдэхүүнд оролцох, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд санал, дүгнэлт гаргах;</p> <p>1.6. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж норм, нормативын баримт бичгийн шаардлагыг ноцтой зөрчсөн хүний амь нас, эрүүл мэндэд сөргөөр нөлүүлж болзошгүй тэр нь тусгай тоног төхөөрөмж болон илтэд нотлогдсон үед хяналтын тухай хууль тогтоомжийн дагуу төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авч, хэрэгжүүлэх,</p> |  |  |  |
|--|--|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--|--|

|    |                      |                                                                                                                                                                                                                                              |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|----|----------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                      | 1.7. Монгол Улсын яам, агентлагийн тушаалаар батлагдсан “Аюулгүйн нөөц”-ийн бэлтгэл, бэлэн байдал, нөхөн хангалт, захиран зарцуулалтад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах тухай албан шаардлага, мэдэгдэл бичих, биелэлтэд хяналт тавих, |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| 75 | 7.5                  | Онцгой байдлын байгууллага гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд хяналт тавих <del>бөгөөд энэхүү чиг үүргийг хөлбөгдөх хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээр гүйцэтгүүлж бөлнө.</del>                                                | - | Тусгаагүй.          | Хуулийн төслийн 7.5-д Онцгой байдлын байгууллага гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд хяналт тавихыг шууд заасан бөгөөд уг чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болохоор зохицуулсан. Иймд саналд дурдсан хяналт хэрэгжүүлэх субъект болон чиг үүргийг хуулийн төсөлд тусгасан.                                                                                                                                                                                 |
| 76 | Хуулийн төслийн 19.4 | Хүч хэрэгсэл дайчлан гаргах үед барилга байгууламж, үйлдвэр үйлчилгээ, газрын зориулалтыг түүний өмчлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр түр хугацаагаар өөрчлөн ашиглаж бөлнө. ашиглана.                                                        | - | Тусгах шаардлагагүй | Хуулийн төслийн 19.4-т хүч хэрэгсэл дайчлан гаргах үед шаардлагатай тохиолдолд барилга байгууламж, үйлдвэр, үйлчилгээ, газрын зориулалтыг өмчлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр түр хугацаагаар өөрчлөн ашиглах боломжийг олгосон. Саналын дагуу “ашиглана” гэж заавал болгох нь хүч хэрэгсэл дайчлан гаргах бүх тохиолдолд тухайн хөрөнгийн зориулалтыг өөрчлөн ашиглах үүрэг үүсгэхээр болж, нөхцөл байдал бүрт шаардлагатай эсэхийг харгалзах боломжгүй болгох тул одоогийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн. |
| 77 | 34.2.13 нэмэлт       | Төр, орон нутгийн өмчийн болон уул уурхай, нэг дор 50-аас дээш хүнд үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллага нь гамшгаас                                                                                                                         | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 34.1.3-т нийтийн үйлдвэр, үйлчилгээ, онц чухал объект, томоохон барилга байгууламж эзэмшдэг, өмчилдөг аж ахуйн нэгж, байгууллага гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны                                                                                                                                                                                                                                                                                                            |

|    |                       |                                                                                                                                                                                                                       |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
|----|-----------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                       | хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, нэгж томилж ажиллуулна.                                                                                                                                               |   |                     | ажилтан, нэгж томилж ажиллуулахаар тусгасан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 78 | 34.2.1                | гамшгаас хамгаалах төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага, иргэн гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.                                            | - | Тусгах шаардлагагүй | Хуулийн төсөлд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах шаардлагыг бүх хуулийн этгээдэд ижил байдлаар тавих бус, үйл ажиллагааны онцлог, ажлын байр, объектын нөхцөлийг харгалзан ялгамжтай зохицуулсан. Тухайлбал 8.5-д үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр явуулдаг, ажлын байр, объектгүй, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг гамшгаас хамгаалах төлөвлөгөөгүй байж болохоор тусгасан.             |
| 79 | 38.2 нэмэлт           | Гамшигтай тэмцэх үйл ажиллагаанд зориулж ирүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хандив, тусламжийг хүмүүнлэгийн тусламж гэж тооцно.                                                                               | - | Тусгасан.           | Хуулийн төслийн 34.1.4-т хуулийн этгээд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх эрхийг тусгасан. Мөн ГХтХ-ийн 4.1.21-т "хүмүүнлэгийн тусламж" гэж иргэн, байгууллага, хуулийн этгээдээс гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулж сайн дурын үндсэн дээр өгч байгаа мөнгөн хөрөнгө, техник хэрэгсэл, бараа материал, ажил, үйлчилгээг; гэж тодорхойлсон. |
| 80 | Хуулийн төслийн 42.10 | Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын Тамгын газарт Онцгой байдлын байгууллагын нэг гамшгаас хамгаалах болон гал түймрийн хяналтын улсын байцаагчийн эрхтэй алба хаагчийг томилж ажиллуулна. | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 42.10-д Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын Тамгын газарт Онцгой байдлын байгууллагын нэг алба хаагчийг томилж ажиллуулахаар тусгасан. Харин уг алба хаагчид гамшгаас хамгаалах болон гал түймрийн хяналтын улсын байцаагчийн эрх олгох талаар тусгайлан зохицуулаагүй.                                                                                    |
| 81 | 42.11 Нэмэлт          | Төв, орон нутгийн Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах                                                                                                                                                    | - | Тусгах шаардлагагүй | Гал түймэр унтраах, аврах анги болон Эрэн хайх, аврах анги нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хамтран ажиллах боловч                                                                                                                                                                                                                                                                               |

|                                                                           |              |                                                                                                                                                                                                                  |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
|---------------------------------------------------------------------------|--------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                           |              | анги, салбарын үйл ажиллагааны чиглэл нэг байна                                                                                                                                                                  |   |                     | гүйцэтгэх чиг үүрэг, мэргэшил, техник хэрэгслийн хувьд ялгаатай.                                                                                                                                                                                                                                                                      |
| 82                                                                        | 50.11        | Орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно.                  | - | Тусгасан.           | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50.11-д нэгэнт тусгагдсан бөгөөд орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа Онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгохоор зохицуулсан.                                                        |
| <b>17. Төв</b> (2026.07.06 44/174, ОБГ, Сумдын Засаг даргын саналын хамт) |              |                                                                                                                                                                                                                  |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                       |
| 83                                                                        | 51.2         | гамшгийн эрсдэлийг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг төрийн байгууллага 2 хувь болгож 1 хувийг гамшгийн үед хэрэглэх, техник тоног төхөөрөмж авах, 1 хувийг үйл ажиллагааны зардалд зарцуулах | - | Хэсэгчлэн тусгасан. | Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх болон бэлэн байдлыг хангах арга хэмжээнд зориулсан тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бий болгох асуудлыг хуулийн төслийн 51 дүгээр зүйлд гамшгийн эрсдэлийг бууруулах сан байгуулах замаар тусгасан.                                                                            |
| 84                                                                        | 51<br>Нэмэлт | Гамшиг ослын шинжгүй, ахуйн дуудлага өгөх, мөн согтуурсан мансуурсан үедээ гамшгийн эрсдэлд орж томилгоот нэгжийг ажиллуулсан тохиолдолд гарах зардлыг төлөх.                                                    | - | Хэсэгчлэн тусгасан. | Гамшиг, ослын шинжгүй ахуйн дуудлагаар томилгоот шуурхай бүлгийг ажиллуулсан тохиолдолд гарсан зардлыг тухайн дуудлага гаргасан этгээдээр хариуцуулах зохицуулалтыг хуулийн төслийн 34.2.12, 37.2.10-т тусгасан. Харин согтуурсан, мансуурсан үедээ гамшгийн эрсдэлд орсон тохиолдлыг зардал төлүүлэх тусгай нөхцөл болгон тусгаагүй. |
| 85                                                                        | Нэмэлт       | Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг жил бүр нарийн мэргэжлийн эрүүл мэндийн үзлэгт хамруулж зардлыг улсын төсвөөс зарцуулна                                                                                | - | Тусгасан.           | Хуулийн төслийн 50.17-д Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, холбогдох зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан.                                                                                                                                                                    |

|                                        |        |                                                                                                                                                                                                                                        |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|----------------------------------------|--------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 86                                     | Нэмэлт | Сайн дурын хэсгийн гишүүдийн урамшууллын асуудлыг хуулийн төсөлд тусгах                                                                                                                                                                | - | Тусгасан.           | Хуулийн төслийн 51.7.3-т гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, урамшуулах арга хэмжээг гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан.                                                                                                                                                                                  |
| 87                                     | Нэмэлт | Гамшгийн үеийн санхүүжилтэд урьд оны татварын гүйцэтгэлээс давсан орлогын 10%-с доошгүйг зарцуулах гэсэн хуулийн зохицуулалт оруулах.                                                                                                  | - | Тусгах шаардлагагүй | Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн эх үүсвэрийг хуулийн төсөлд улсын болон орон нутгийн төсвийн нэмэлт санхүүжилт, зээл, тусламж, хандив болон хуульд заасан бусад эх үүсвэрээр бүрдүүлэхээр олон эх үүсвэрийн зарчимд тулгуурлан зохицуулсан. Иймд өмнөх оны татварын гүйцэтгэлээс давсан орлогын 10-аас доошгүй хувийг заавал гамшгийн үеийн санхүүжилтэд зарцуулах тусгай хувь тогтоох шаардлагагүй. |
| 88                                     | Нэмэлт | Орон нутгийн гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр жил бүрийн төсөвт тодорхой зүйл анги бий болгон тоног төхөөрөмжийн шинэчлэлт, урсгал зардлын асуудлыг тусгаж байх хуулийн зохицуулалт оруулж өгөх. | - | Хэсэгчлэн тусгасан. | Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн санхүүжилтийн эрх зүйн үндсийг хуулийн төслийн 51 дүгээр зүйлд гамшгийн эрсдэлийг бууруулах сан байгуулах замаар тусгасан. Тус сангийн хөрөнгийг гамшгийн өмнөх үйл ажиллагаа, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ, сайн дурын хэсэг, сайн дурын ажилтны бэлэн байдлыг хангах зэрэгт зарцуулахаар зохицуулсан.                         |
| <b>18. Увс (2026.07.08 45/285 ОБГ)</b> |        |                                                                                                                                                                                                                                        |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| 89                                     | 51.2   | 51.2-т заасан төсвийг гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн дарга захиран зарцуулах эрхийг олгох.                                                                                                                        | - | Тусгах шаардлагагүй | Хуулийн төслийн 51.8-д аймаг, нийслэл, дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгийг тухайн шатны Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн шийдвэрээр төлөвлөж, зарцуулахаар зохицуулсан. Энэ нь гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих нутгийн                                                                    |

|    |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|----|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|    |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |   |                     | өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхтэй уялдсан.                                                                                                                                                                                                                                                                                            |
| 90 | Хуулийн төслийн 7.5 | Гамшгийн эрсдэлийн үнэлгээнд хяналт тавих албан тушаалтныг зааж өгөх.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | - | Тусгасан.           | Хуулийн төслийн 7.5-д гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд Онцгой байдлын байгууллага хяналт тавихаар тодорхой заасан бөгөөд уг чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болохоор зохицуулсан.                                                                                                      |
| 91 | -                   | Улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын чадавхыг нэмэгдүүлэх ажлыг улс, орон нутгийн төсвөөс хараат бусаар өөрсдийн нөөц боломжийг ашиглан олон улсын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагатай хамтран төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төсөв санхүүгийн хувьд бие даан шийдвэрлэх боломжийг нээх эрх зүйн зохицуулалтыг тусгах; | - | Хэсэгчлэн тусгасан. | Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшил болон бусад байгууллагын оролцоо, дэмжлэгийг хангах боломжийг хуулийн төсөлд хуулийн этгээдийн санхүүгийн дэмжлэг, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх эрх, мөн гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн эх үүсвэрт зээл, тусламж, хандив болон бусад эх үүсвэрийг хамруулах замаар зохицуулсан. |

|                                                                           |    |                                                                                                                                                                                                                                                                  |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|---------------------------------------------------------------------------|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 92                                                                        | -  | Гамшгаас хамгаалах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд гамшгийн даатгалын тогтолцоог нэвтрүүлж, эрсдэл хуваалцах, гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд даатгалын салбарыг татан оролцуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 34.1.5-д хуулийн этгээд үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн холбогдох даатгалд хамрагдах, даатгалын нөхөн төлбөр авах эрхийг тусгасан. Харин гамшгийн даатгалын тогтолцоог бие даан бүрдүүлэх, даатгалын салбарыг гамшгийн эрсдэлийг хуваалцах тогтолцоонд оролцуулах нарийвчилсан зохицуулалтыг тусгаагүй. Даатгалын бүтээгдэхүүн, даатгалын төрөл, албан журмын даатгалтай холбоотой харилцаа нь Даатгалын тухай хууль болон холбогдох тусгай зохицуулалттай уялдах тул уг тогтолцоог Гамшгаас хамгаалах тухай хуульд дангаар нь бий болгох боломжгүй. |
| 93                                                                        | -  | Иргэн, албан газар, аж ахуй нэгж байгууллага нь өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж гамшиг ослын дуудлага мэдээлэл өгсөн тохиолдолд гарсан шатах, тослох материалын зардлыг холбогдох баримтын дагуу нөхөн төлөх талаар хуульд тусгаж өгөх.                   | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 34.2.12, 37.2.10-т гамшиг, ослын шинжгүй ахуйн дуудлага өгч томилгоот шуурхай бүлгийг ажиллуулсан тохиолдолд хуулийн этгээд, иргэн холбогдох зардлыг хариуцахаар тусгасан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
| <b>19. Ховд (2026.07.06 46/227 ОБГ, сумдын Засаг даргын саналын хамт)</b> |    |                                                                                                                                                                                                                                                                  |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| 94                                                                        | 36 | 36 дугаар зүйл болон "Сайн дурын хэсэг" томилох, ажиллуулах, сургалт мэдээлэл өгөхөд журмаар болон хуулиар тодорхой болгох, анхан шатны дадлага эзэмшүүлэх, урамшуулахад төсөв санхүүг нь тодорхой тодорхой болгох                                               | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 36 дугаар зүйлд гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, сайн дурын ажилтны эрх зүйн байдлыг зохицуулж, 36.4-т тэдгээрийн ажиллах журмыг Засгийн газар батлахаар тусгасан. Мөн төслийн 51.7.3-т сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, урамшуулах арга хэмжээг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр, 51.6-д сангийн эх                                                                                                                                                                      |

|                                                                         |   |                                                                                                                                    |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|-------------------------------------------------------------------------|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                         |   |                                                                                                                                    |   |                     | үүсвэрийг тус тус тодорхойлсон. Иймд саналын сайн дурын хэсгийг ажиллуулах, сургалт, бэлтгэл, урамшуулал болон санхүүжилтийн үндсэн агуулгыг төсөлд тусгасан.                                                                                                                                                                                                            |
| <b>20. Хөвсгөл (2026.07.06 47/193 Сумдын Засаг даргын саналын хамт)</b> |   |                                                                                                                                    |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 95                                                                      | - | 2000 болон түүнээс дээш оршин суугчтай сум, суурин газарт гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан тушаалтанг томилон ажиллуулах | - | Тусгасан.           | Хуулийн төслийн 42.10-д Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын Тамгын газарт Онцгой байдлын байгууллагын нэг алба хаагчийг томилж ажиллуулахаар тусгасан. Ингэснээр саналд заасан 2,000 болон түүнээс дээш хүн амын босгоос үл хамааран ОБ-ын салбар, нэгжгүй бүх сумыг хамруулах эрх зүйн үндэс бүрдсэн.                                        |
| 96                                                                      | - | Нас хүйс, эрхэлж буй ажил үйлчилгээнээс хамаарч жилд 1-ээс доошгүй удаа гамшгаас хамгаалах сургалтад оролцох                       | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 13 дугаар зүйлд гамшгаас хамгаалах сургалтад хамрагдах этгээдийн ангиллыг тодорхой болгож, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах зохицуулалтыг боловсронгуй болгосон. Тухайлбал, 13.2.3-т боловсролын байгууллагад суралцагч, 13.2.5-д гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийг сургалтад хамруулахаар тусгасан. |
| 97                                                                      | - | Төөрч алга болсон дуудлагаар Эрэн хайх, аврах бүлэг түргэн шуурхай хүрэлцэн ирж цагийн байдлыг үнэлж шуурхай арга хэмжээ авах      | - | Тусгах шаардлагагүй | Хуулийн төсөлд эрэн хайх, аврах ажиллагааны агуулгыг тодорхойлж, хүн, мал, амьтан, эд хөрөнгийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх арга хэмжээг хамруулсан. Дуудлагаар Эрэн хайх, аврах бүлэг түргэн шуурхай хүрэлцэн ирж цагийн байдлыг үнэлэх ажиллагааг холбогдох журмаар зохицуулна.                                                              |
| 98                                                                      | - | Гамшгийн үед өндөр эрсдэлтэй бүлгийн иргэдийн /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн эмэгтэй/                         | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 4.1.6-д “аюулыг тэсвэрлэх байдал” гэсэн ойлголтыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, нийгмийн болон физикийн эмзэг байдлыг хамруулах болсон.                                                                                                                                                                                                        |

|     |    |                                                                                                                                                                                                                                          |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|-----|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|     |    | хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулж, гамшгаас урьдчилан сэргийлэх гамшгийн үед болон гамшгийн дараа бэрхшээлийн хэлбэрт тохируулан тусгай зохицуулалт, дэмжлэгийг төлөвлөн хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг нэмэлт заалтаар оруулах. |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| 99  | 13 | ЕБС-д гамшгаас хамгаалах сургалтыг зааж сургах энэ талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулах /сургууль хариуцах/                                                                                                                      | - | Тусгасан.           | Хуулийн төслийн 13.2.3-т сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийг гамшгаас хамгаалах сургалтад хамруулахаар, 13 дугаар зүйлд сургалт, сурталчилгаа зохион байгуулах, мэдээллээр хангах зохицуулалтыг тусгасан. Мөн Боловсролын ерөнхий хуулийн 14.4.7-д гамшгаас хамгаалах, аюулгүй амьдрах арга ухааныг боловсролын сургалтын хөтөлбөрт заавал тусгахаар зохицуулсан тул ерөнхий боловсролын сургуульд гамшгаас хамгаалах мэдлэг олгох санал эрх зүйн хувьд зохицуулагдсан. |
| 100 | -  | Гамшгийн үед сайн дураар ажилласан иргэнд төрөөс урамшуулал олгох                                                                                                                                                                        | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 51.7.3-т гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, урамшуулах арга хэмжээг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан.                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| 101 | -  | Онцгой байдлын байгууллагын удирдлагын эрх мэдэл хэт төвлөрөхөөс сэргийлж, хариуцлагын тогтолцоог тусгах                                                                                                                                 | - | Тусгах шаардлагагүй | Хуулийн төслийг боловсруулахдаа гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцооны давхардал, хийдлийг арилгаж, төрийн болон орон нутгийн удирдлагын бүрэн эрх, гамшгийн үеийн удирдлагын                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |

|                                                                                       |                                |                                                                                                                                                                                                                          |                                                                                    |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
|---------------------------------------------------------------------------------------|--------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------|---------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                       |                                |                                                                                                                                                                                                                          |                                                                                    |                     | заагийг тодорхой болгох зарчмыг баримталсан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| 102                                                                                   | -                              | Төөрч алга болсон дуудлага мэдээлэл ирсэн тохиолдолд аймгийн Цагдаагийн газрын бүрэлдэхүүн түргэн шуурхай ирж гэмт хэргийн шинжтэй эсэхийг шалгах                                                                        | Сум орон нутагт сумын Цагдаа шалтгаан нөхцөлийг тодорхой болгох гэж хугацаа алддаг | Тусгах шаардлагагүй | Саналд дурдсан гэмт хэргийн шинжийг шалгах, цагдаагийн алба хаагчийн шуурхай ажиллагааны зохион байгуулалт нь цагдаагийн байгууллагын чиг үүрэгтэй холбоотой бөгөөд Гамшгаас хамгаалах тухай хуулийн зохицуулах харилцаанаас гадуур байна. Хуулийн төсөлд эрэн хайх, аврах ажиллагааны агуулгыг 4.1.10-т тодорхойлж, гамшгийн үед хэрэгжүүлэх хүч хэрэгсэл, харилцан ажиллагааны эрх зүйн үндсийг зохицуулсан. Иймд цагдаагийн байгууллагын гэмт хэргийн шинжийг шалгах ажиллагааны хугацаа, зохион байгуулалтыг энэ хуульд тусгайлан зохицуулах шаардлагагүй. |
| <b>21. Хэнтий (2026.07.07 48/219, ОБГ, ЗДТГ, төрийн байгууллагуудын саналын хамт)</b> |                                |                                                                                                                                                                                                                          |                                                                                    |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
| 103                                                                                   | Хуулийн төслийн 32.1.15 Нэмэлт | "Бүх шатны Засаг дарга нь нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор багаж хэрэгслээр хангах, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж, худалдан авч болно" | -                                                                                  | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 32.1-д Засаг даргын гамшгаас хамгаалах бүрэн эрхийг, тухайлбал 32.1.10-т орон нутгийн Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэхээр тусгасан. Мөн 51 дүгээр зүйлд гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг тодорхойлсон.                                                                                                                                                                  |
| 104                                                                                   | Нэмэлт                         | "Гамшгийн үед иргэд болон тээврийн хэрэгслийг дайчлан ажиллуулах тохиолдолд тухайн иргэн аж ахуйн нэгжид урамшуулал олгох"                                                                                               |                                                                                    | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 4.1.13-т "хүч хэрэгсэл дайчлан гаргах" ойлголтыг тодорхойлж, иргэн, хуулийн этгээдийг эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд татан оролцуулах, эд хөрөнгө, газрыг ашиглахтай холбогдох зохицуулалтыг тусгасан. Мөн 19.5 "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл болон эзэмшлийн эд                                                                                                                                                                                                                  |

|     |        |                                                                                                                                                                                                                                               |   |                     |                                                                                                                                                                                                                                                                                                                       |
|-----|--------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---|---------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|     |        |                                                                                                                                                                                                                                               |   |                     | хөрөнгө, бараа материал, газар, барилга байгууламжийг дайчилсан тохиолдолд энэ хуулийн 20.4-т заасан журмын дагуу холбогдох зардлыг төрөөс олгоно." Гэж тус тус нэмсэн.                                                                                                                                               |
| 105 | Нэмэлт | "Гамшгаас хамгаалах тусгай болон ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдал, хувцас хэрэгсэл, техник, багаж хэрэгслээр хангаагүй тухайн шатны Засаг даргад хариуцлага тооцох" гэж: нэм                         | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төсөлд гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн эрх зүйн байдлыг тодорхой болгож, Засаг дарга нь орон нутгийн Онцгой байдлын байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг ажиллах нөхцөл, боломжоор хангах, дэмжлэг үзүүлэхээр тусгасан.                                                               |
| 106 | Нэмэлт | "Гамшгаас хамгаалах тусгай болон ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд томилогдсон ажилтан, алба хаагч, иргэн нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох" гэж                                                          | - | Тусгах шаардлагагүй | Үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг зөрчил, гэм буруугийн шинжээс хамааран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх тул Гамшгаас хамгаалах тухай хуульд хариуцлагын ерөнхий заалтыг давхар тусгах шаардлагагүй.                                                                                  |
| 107 | Нэмэлт | "Гамшгаас хамгаалах тусгай болон ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн гал түймэр, гамшиг, аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд үүргээ гүйцэтгэсэн ажилтан, алба хаагч, иргэнд томилолт урамшуулал олгох" | - | Хэсэгчлэн тусгасан. | Хуулийн төслийн 51.7.3-т гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, сайн дурын ажилтныг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах, урамшуулах арга хэмжээг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан. Мөн гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бүрэлдэхүүнд мэргэжлийн анги хамаарахаар тодорхойлсон. |

#### ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР